



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/59

Мөрөн сум

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг  
мөрдөж ажиллах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 66 дугаар 66.1, Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 159 дүгээр зүйлийн 159.2 дахь заалтууд, Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2023 оны 12 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагууд, хувиараа хөдөлмөр эрхлэгч нь хөдөлмөрийн гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээ, тэдгээртэй адилтгах бусад гэрээгээр ажиллуулж байгаа ажилтны цалин хөлсний доод хэмжээг сард 660.000 төгрөгөөр тооцон олгох тухай Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн үндэсний хорооны 2023 оны 12 дугаар тогтоолыг мөрдлөг болгон ажилласугай.

2.Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2023 оны 12 дугаар тогтоол болон энэхүү захирамжийн хэрэгжилтийн талаар хагас жил тутамд аж ахуйн нэгж, байгууллагуудад хяналт шалгалт хийж, үр дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулж ажиллахыг аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Раднаабүд)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны А/56 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Э.Улам-Өсөх)-д даалгасугай.

ДАРГА  П.ЛХАГВАЖАВ

